



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/30

Чингис хот

Ардын их хурлын депутатуудад хүндэтгэл
үзүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тохиолдуулан Хэнтий аймгаас сонгогдсон ардын их хурлын депутатуудад хүндэтгэл үзүүлэхэд 6342500 /Зургаан сая гурван зуун дөчин хоёр мянга таван зуун/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010126

Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Дүн
1	Байрлах байр /2 ортой өрөө/	8	120000*2=240000	1920000
2	Байрлах байр /1 ортой өрөө/	1	150000*2=300000	300000
3	Өдрийн хоол	13	15000	195000
4	Оройн хоол	18	20000	360000
5	Хүндэтгэлийн зоог	18	58000	1044000
6	Чөлөөт цаг	2	100000	200000
7	Бэлэг дурсгалын зүйл	13	150000	1950000
8	Шатахуун	150л	2490	373500
Нийт дүн				6342500